



ТӨСЛИЙН БАГ ХЭНТИЙ, БУЛГАН АЙМГУУДАД АЖИЛЛАВ

8-р сарын 27-30 ны өдрүүдэд тус аймгуудын зарим зөгийчдэд зөвлөгөө өгч холбогдох хүмүүстэй уулзалт хийлээ.

Төслийн баг 8-р сарын 27, 28-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Биндэр суманд ажиллав. Энэ үеэр сумын удирдлагауудтай уулзаж санал солилцов. Мөн зөгийчдэд (17 хүн) зөгийн бүлийн намрын арчилгаа болон өвөлжүүлэх бэлтгэлийн талаар зөвлөгөө өгөв. Зөгийчдийн бүлгийн ахлагч н.Оюунчимэгийн зөгийн суурьт очиж түүний зарим арга туршлагатай танилцахад зөгийн балны чанар, суурь орчмын эрүүл ахуйг сайжруулах өвөрмөц санаа (доорх зургаар харуулав) гарч байсан ба эдгээрийг нэгдсэн гарын авлагад оруулах нь зүйтэй гэж үзлээ.

8-р сарын 30-ны өдөр Булган аймгийн ХАА-н МСҮТ-д ажиллаж өнгөрсөн оны 4-р сараас эхлэн хамтран боловсруулж буй сургалтын хөтөлбөрийн шинэчлэн бэлтгэх хувилбарын талаар зөвлөлдөв. Мөн тус сургуулийн багш нарт зөгийн бүлийг өвөлжилтөнд бэлтгэх технологийг зөвлөгөө өглөө.



(Дээд тал) Сургуулийн удирдлага, багш нартай хийсэн уулзалт. (Доод тал) Технологийн дадлагын үед.

Тус төсөл нь Монгол орны ЗАА-д ашиглагдах нэгдсэн гарын авлага боловсруулан бэлтгэхээр ажиллаж байна. Нэгдсэн гарын авлагыг орон нутагт хэрэгжиж буй үйл ажиллагааны үр дүнг тусгах байдлаар эмхэтгэн боловсруулах болно.



(Зүүн тал) Балтай жааз (4ш) зөөвөрлөх тагтай хайрцаг. (Баруун тал) Зөгий суухаас сэргийлж бохирыг тухай бүр шороогоор булж байх нүхэн жорлон.

21 дэхь удаагийн онлайн хичээлийг бэлтгэн хүргэв

Тус хичээлийг 8-р сарын 31-ны өдөр төслийн фэйсбүүк хуудсанд байршуулав. Энэ удаад зөгийн бал хэрэглэгч нарт зориулж зөгийн балны онцлог, ялгаатай байдлын тухай мэдээлэл хүргэхээс гадна чанарыг хэрхэн ялгаж мэдэх тухай танилцуулав. Мөн дүрс бичлэгээр сахарын агууламж өндөр болон бага зөгийн балны ялгааг харуулсан байгааг үзэж сонирхоорой.

< Сахарын үзүүлэлт >

- Стандартас хамгийн ойгоход хялбар зүйлийн нэг нь сахарын үзүүлэлт юм.
- Сахарын үзүүлэлтийг чанд мөрдөж зөгийн бал үйлдвэрлэсэн зөгийчид бэл зөгий маллагаа технологийн дагуу хялж, сайн чанарын зөгийн бал хурва гэжг уламжлалтай байгааг хэрэглэж.
- Зөгийчид бүр зөгийн балны чанарт амьсгалыг хянаж байгааг.
- Бүрэн хянасан боловсруулсан зөгийн бал хурвалжана.
- Сахар хэмжээг хянаж сахарын үзүүлэлтийг хянасан зөгийн балны хэрэгжээд нийтлүүлсэн.

ТА ДООРХ ЗААВАРЫГ МЭДЭХ ҮҮ?

“ЗӨГИЙН АЖ АХУЙД МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГЫГ МӨРДӨХ НИЙТЛЭГ

ЗААВАР : General Guideline for Veterinary Services and Hygiene Requirements to Be Implemented in Bee Farms” Тус заавар нь 2019 оны 4-р сарын 29-ны өдөр МЭЭГ-ын даргын тушаалаар батлагдсан.

Энэ заавраар зөгийн бүлд тохиолдох өвчин, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл ахуйг мөрдөх болон зөгийн балны чанар, аюулгүй байдлыг баталгаажуулахад талуудын гүйцэтгэх үүрэг зэрэг харилцааг зохицуулсан болно. ЗАА эрхлэгчид малын эмчтэй гэрээ байгуулж тэднээс мэргэжлийн дэмжлэг авах, улмаар зөгийн бүл болон зөгийн балны гарал үүслийг баталгаажуулах юм. Энэхүү арга барилыг тус төслийн 1-р үе шатанд хэрэгжүүлж туршсан бөгөөд тус зааврын төслийг боловсруулах зэргээр бодлого боловсруулагч талтай хамтран ажилласан болно. Цаашид төслийн зүгээс тус заавраар зохицуулагдсан ЗАА болон мал эмнэлэг хоорондын харилцааг улсын хэмжээнд хэрэгжихэд дэмжлэг үзүүлэн ажиллах юм.

Нийтлэг зааврыг бүрэн эхээр нь BeeDep фэйсбүүкаас доорх хаягаар үзэж болно.

<https://www.facebook.com/107843977265085/posts/614387249944086/?d=n>

Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

